

# МОНГОЛ, СОЛОНГОСЫН ХООРОНДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗАГВАР

Парк-Ки-Ань\*

Монголд компани болон оролцохыг голлов.

## I. Солонгосын эдийн засгийг Монголд ойртуулах нь:

Харилцан ашигтай байх сонирхол, шаардлагын улмаас эдийн засгийн харилцаа хөгжинө. Өнгөрсөн үед ЗСБНХУ-аар толгойлуулсан социалист орнуудын төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг нь эдийн засгийн хөгжлийг саатуулж үр ашиггүй байдалд хүргэсэн юм.

Монголын эдийн засаг төвлөрсөн төлөвлөлтийн /тогтолцоот үзэл/ концепци дээр тулгуурлаж байсныг бид мэднэ. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг эхний шатандаа тодорхой хэмжээний амжилт олж байсан боловч, эцсийн дүндээ өдөр тутмын хэрэгцээт зүйлийн эрс хомсдол бий болгожээ. Үүний зэрэгцээгээр эдийн засгийн бүтцийн улмаас технологи, бизнесийн шинэчлэлт байхгүйгээс болж аль ч салбарт бүтээмж буурч, үр өгөөжтэй ашиглах ёстой монголын байгалийн нөөц баялагийн ашиглалт хамгийн доод хэмжээнд хүрсэн байна. Иймэрхүү үр ашиггүй байдлыг арилгахын тулд Монгол улс зах зээлийн зарчмаар шинэчлэлт хийж, гадагшаа хандсан бодлого явуулах боллоо.

Монголын эдийн засгийн гадаад харилцааг сайжруулах арга хэмжээ нь түүний эдийн засгийн механизмын бүтцийг өөрчлөхтэй холбогдонс. Монголчууд гадаадын фирмүүдтэй шууд холбоо тогтоон, хамтын үйлдвэр байгуулж, олон улсын холбоо байгууллагад элсэж эхлээд байна. Монголын эдийн засаг нь бүтцийн зөрчил, хөрөнгө оруулалтын фонд байхгүй бэйгаа, эдийн засгийн хэмжээ багатай, сул дорой,

---

\*Парк-Ки-Ань. гүн ухааны доктор, профессор, олон улсын бизнес, маркетингийн ухаанаар дагнан мэргэжсэн. Хөндлөн их сургуулийн Ази, Номхон далай судлалын төвийн дэд захирал, энэхүү өгүүллийг тус сэтгүүлд зориулан бичиж ирүүлжээ. Сеул. 130-170.

байгалийн нөөцийг ашиглахад шаардлагатай хөрөнгийг нэмэгдүүлж чадахгүй байгаа, мөн аж үйлдвэрийн болон өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэлийн хооронд тэнцвэргүй байдал ихэссэн зэрэг олон хүнд асуудалтай тулгарсан юм.

XXI зуун Ази, Номхон далайн эрин үеэхээр болно гэдгийг зөвшөөрөн энэ бүс нутгийн тулгуур улсуудын нэг гэж үзэж буй Солонгостой тогтоосон харилцааны түвшинг дээшлүүлэхийг Монгол их сонирхож байна.

Солонгос бол технологи, капитал, тэдгээрийг нэвтрүүлэх ажиллагааны хувьд чөлөөт ертөнцтэй эдийн засгийн харилцаа бэхжүүлэх талаар хамгийн сайн түнш болохоо харууллаа. Энэ талаар гайхмаар нотолгоо байна. Солонгос байгалийн нөөц, түүхий эд байхгүй боловч, нэхмэл, гутал мэтийн өргөн хэрэглээний зүйл, өнгөт телевизор, видеотехник зэрэг электрон бараа, хагас дамжуулагч, компьютер мэтийн өндөр технологитой бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, амжилт олж, хөгжиж буй орнуудын хувьд эдийн засгийн загвар болж байна. Бүс нутгийн орнууд Солонгосын дигамик дэвшлийг хараад, түүнтэй нягт харилцаа тогтоохыг улам эрмэлзэх боллоо. Монгол мэтийн орон Солонгостой эдийн засгийн хамтын ажиллагаагаа өргөтгөхийг эрмэлзэж байна. Ялангуяа Солонгосын эдийн засгийн хөгжлийн амжилт, харилцан ашигтай харилцаа тогтоох далд боломж байгаа учир түүнтэй эдийн засгийн нягт холбоо тогтоохыг Монгол эрмэлзэх боллоо.

Солонгосын хувьд экспортын зах зээлийг олон янзын арга хэлбэрээр бий болгох нь эдийн засгийн маргааны хамгийн эгзэгтэй асуудал байсаар байдаг. Зах зээлийг олон янзын арга хэлбэрээр эрэлхийлэхээр зөвхөн хязгаарлагдадаггүй. Монголд байгалийн нөөц, түүхий эдийн хангамж элбэг байх нь алстаа хамгийн сонирхол татах онцлог болох нь тодорхой.

Дээр дурьдсанаар бол нягт хамтын ажиллагааны харилцаагаа эвчимжүүлэх нь Солонгос, Монголын хувьд улам чухал болсоор байна. Солонгос, Монгол хоёр эдийн засгийн холбоогоо өргөжүүлэхийг эрмэлзсээр байгаа боловч хоёр орны эдийн засгийн системийн ялгаа, мөн баталгаа байхгүй байгаа нь эдийн засгийн харилцааг цааш хөгжүүлэхэд хязгаарласан хүчин зүйл болсоор байна. Солонгос, Монголын эдийн засгийн хамтын ажиллагааны стратегийг яаж гүнзгийрүүлж болох вэ? гэдэг асуудлыг энэ өгүүлэлд авч үзнэ.

## 2. Солонгос, Монголын хоорондын эдийн засгийн харилцааны одоогийн байдал

1988 он хүртэл Солонгос, Монголын хоорондох худалдаа Монголоос Солонгост оруулах импортоор хязгаарлагдаж байсан бол дипломат харилцаа тогтоосноос хойш хоёр талын бараа худалдааны хэмжээ 1990 онд 2706 мянган доллар болж өсөв. Монголд оруулах Солонгосын экспорт 1989 онд 140000 ам. доллар байсан бол 1990 онд 515000 ам. долларт хүрч, урьд оныхоос 267,4 хувиар өсчээ. Монголоос оруулах импорт 1990 онд 2191000 ам. доллар болж урьд оныхоос 373 хувиар өсчээ. Солонгос Монголтой хийх импорт, экспорт жил бүр улам өссөөр байна. Солонгос Монголтой хийж буй худалдааны бүтцийг үзэхэд Монголд ихэвчлэн электроны зүйл, нэхмэл, оптик, машин техник, гутал, олд оруулж, ширэм, зэс, цагаан тугалга мэтийн янз бүрийн түүхий эд авч байна.

Одоо Солонгос, Монголын хоорондын эдийн засгийн харилцаанд их төлөв худалдаа зонхилж байна. Солонгос, Монголын хоорондын худалдаа нь Солонгосоос аж үйлдвэрийн бараа, Монголоос түүхий эд авахаар хязгаарлагдаж байгаа нь илэрхий боловч аж үйлдвэр, эдийн засгийн хамтын ажиллагааны түвшин ихсэж, улам найрсаг харилцаатай болсоор байгаа нь худалдаа их өргөжихөд тулхэц болох юм. Харин хамтын үйлдвэрийн маягаар үйлдвэр экспортлох нөөц баялгийг боловсруулах талаар бизнесийн их далд боломж /потенциал/ байна гэж Солонгосын компаниуд үзэж байна. Солонгос, Монголын эдийн засгийн

харилцаа нь хамтарсан үйлдвэр байгуулах, биеэ даасан хөрөнгө оруулалт хийх хэлбэрээр өргөжиж байна.

Монголтой хийсэн Солонгосын худалдаа /мянган доллар/ \*

Он	1986	1987	1988	1989	1990	1991 оны IX сар
Экспорт	0	0	0	140	515	7700
Импорт	171	135	573	463	2199	-

Солонгос, Монголын хоорондын худалдааны ирээдүйн төлөв аятайхан байгаа тул хоёр талын хамтын ажиллагааны хүрээ, бизнесийн ажиллагааны аргыг янз янз болгоход бидний сонирхол чиглэгдэх ёстой. Монгол нь зах зээл дээр үндэслэсэн эдийн засагт шилжих гэж асар их чармайж байгаа боловч ихэд хоцрогдсон үйлдвэрийн салбар олон байна. Тэдгээр салбар нь бүтээгдэхүүний эцсийн хэрэглэгчидтэй шууд холбох үүрэг гүйцэтгэх нь олонтаа байна. Ирээдүйд Монголын зах зээлийн томоохон потенциалыг харгалзан үйлчилгээний салбарт ч ихээхэн хөрөнгө оруулах ёстой.

Монголыг сонирхож буй Өмнөд Солонгосын ихэнх пүүсүүд үйл ажиллагаандаа олон зорилго тавьж байна. Түүнээс гадна бүх компани гадаад хөрөнгө оруулалтаа догоод хөрөнгө оруулалттайгаа адил авч үзэхгүй байна.

Гадаад хөрөнгө оруулдаг Солонгосын компаниудыг стратегийн зорилгоор нь зах зээл эрэгч, түүхий эд эрэгч, бүтээгдэхүүний үр ашиг эрэгч, эрдэм /мэдлэг/ эрэгч гэх мэтээр хэдэн хэв маяг болгон ангилж болно. Монголд хөрөнгө оруулахаар төлөвлөн хэлэлцээр хийж буй солонгос компаниуд нь түүхий эд эрэгчид өөрөөр хэлбэл Солонгосод аж үйлдвэр хөгжүүлэхэд хэрэгцээт байгалийн нөөцийн удаан хугацааны хангамжийг баталгаатай болгохын тулд Монголд ирэхийг хүсч байна. Энэ нь Солонгосын фирмүүдээс бусад оронд оруулдаг гадаадын шууд хөрөнгө оруулалтынхаас ялгаатай. Солонгос нөөц ховортой болохоор шаардагдах байгалийн нөөцийн ихэнхийг импортолдог. Солонгосын компаниуд монголын зах зээлийн хувьд мөн бүтээгдэхүүний үр ашиг эрэгчид юм. Тэд Монголд ирэхдээ үр ашигтай ажиллах хүчнийг хямд үнээр элсүүлэх болно.

1992 оны 7-р сарын эхээр Солонгосын аж үйлдвэрийн тэргүүлэх бүлгүүдийн нэг болох "ДЭҮ" корпорац монголын талтай барагцаалбал 9 сая америк доллараар үнэлэгдэх хөрөнгө оруулалтын төслийн хэлэлцээ хийж эхэлсэн билээ. Энэ хэлэлцээж байгаа хөрөнгө оруулалтын төсөл хэрэв завшээрөгдөх юм бол Монголд оруулах жинхэнэ хөрөнгө оруулалт идэвхжинэ. Монголд оруулах солонгосын хөрөнгө оруулалт нь богино хугацааны өргөн хэрэгцээний бараа үйлдвэрлэх нэг талын үйлдвэрт голлон чиглэгдэх болно. Урт хугацааны хамтын ажиллагааны хувьд Монголын байгалийн нөөц хамгийн өгөөжтэй нь юм. Энэ нь Монголтой эдийн засгийн өргөн холбоо тогтоох нь ашигтай болохыг гэрчилнэ.

### 3. Компаниуд оролцох эдийн засгийн хамтын ажиллагааны загвар

Монголын одоогийн байдлаас үзэхэд өрсөлдөхүйц технологийг шилжүүлэх, хэрэглэх, цаашдын алхам болгон хуваарилах, бүтээх, мөн жуулчлал, байгалийн нөөц баялгийг боловсруулах, хоёр талын сонирхсон бусад салбарт хөрөнгө оруулах мэтийн солонгосын оролцоо

\*IPEC and Macil Kyungje Shinmoon-ийг ашиглав.

хамгийн их гэрээрдэгдэж байгаа салбар руу эдийн засгийн хамтын ажиллагаа голлон чиглэгдэх ёстой.

Хамтын ажиллагааны боломжтой салбарууд гэвэл хувцас, арьс шир, мөн бусад завсрын түвшингийн технологи, хамтын зах зээлийн ажиллагаа, жишээлбэл экспортын бараа, аж үйлдвэрийн дизайн хөгжүүлэх талын үйлдвэрүүдийн шууд хамтын ажиллагаа, хамтын маркетинг онцлох хэрэгтэй болох байх. Ялангуяа байгалийн нөөцийг боловсруулахад Солонгос оролцохыг хүсч буйг энд дурдаж болно.

#### I. I-р загвар: аж үйлдвэрийн хамтын ажиллагааны хэлбэр

Аж үйлдвэрийн хамтын ажиллагаа нь байгаа үйлдвэрийг нэмэн өргөтгөх, шинэчлэн тоноглох үндсэн дээр технологи нэвтрүүлэх, мэргэжилтэй ажиллах хүч нилгээхэд голлон чиглэгдэх ёстой байх. Үүний зэрэгцээ олон улсын хөдөлмөрийн хуваарийг өргөтгөх замаар дэлхийн эдийн засгийн тэвцэнд хамтран гарах чармайлтын талаар тохиролцоно.

Манай хоёр орны хоорондын аж үйлдвэрийн хамтын ажиллагааны гол онцлог гэвэл Монголын тал ажиллах хүч, үйлдвэрийн газар, барилгыг, Солонгосын тал ерөнхийдөө Солонгосын үйлдвэрлэлийн хэрэгслэлд бие дэлээ олсон техникийн ур ухаан, мөн ирээдүйн бүтээгдэхүүнийг гуравдагч орон, эсхүл монголын зах зээлд борлуулах маркетингийн ажлыг хариуцана. Менежментийн зохицуулалт, ашиг хуваалт нь янз бүрийн тохиолдолд янз янзаар хийгдэнэ. Солонгос, Монголын эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээрт, хоёр орны системийн гол байгууллагын хоорондох ялгаатай нөхцөлд хэрхэн зохицож ажиллах арга замыг заана. Монгол нь үйлдвэрлэлийн хэрэгслэлийг албан ёсоор өмчлөгч байх боловч тэдгээрийг үр ашигтай хэрэглэхийн тул өмчлөлийн зарим чухал функцийг Солонгосын талтай хуваалцана. Энэ бол уг асуудалд хандах практик тал мөн бөгөөд энэ нь хамтын ажиллагааны янз бүрийн салбарын онцлог асуудалтай уялдаж олон янзын хэлбэрээр хэрэгжинэ.

Солонгосын тал тухайн фирмийн албан ёсны өмчлөх эрхийг бүрмөсөн худалдан авахыг хүсвэл гарах маргааныг зохицуулж болохоор зохион байгуулалтын шинэ хэлбэрээр шийдвэрлэнэ. Гадаадын хөрөнгө оруулалтыг яаж зэрэг үр өгөөжтэй ашиглахыг Солонгос, Монголын үйлдвэрүүдийн хооронд байгуулсан гэрээ хэлэлцлийн дагуу шууд хамтын ажиллагааны хэлбэрт тодорхой тусгасан байна. Цаашилбал, Солонгос, Монголын харилцаанд аж үйлдвэрийн хамтын ажиллагааны төлөвлөн буй эрийн хэлбэр нь үйлдвэр оруулах, тоног төхөөрөмжөөр хангах зэрэг болно. Энэ тохиолдолд эцсийн бүтээгдэхүүний төлбөр, лавшруулсан гэрээ, хамтын бүтээгдэхүүнээ хэрхэн тооцох тухай зэрэг асуудал хөндөгдөнө. Үүний эхнийх нь ерөнхийдөө бүрэн үйлдвэр оруулах, дараагийнх нь тоног төхөөрөмж суурилуулах буюу бүтээгдэхүүн үйлдвэрлэх шугам шинээр тавих хэлбэр юм. Энэ нөхцөлд үнийг үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн буюу уг төхөөрөмжөөр боловсруулсан түүхийг эдээр төлнө. Ер нь нийлүүлэгч тал нь үйлдвэрийн машин, тоног төхөөрөмж нийлүүлэхээр барахгүй, уг үйлдвэрийн төлөвлөгөө, ажиллуулах арга ухаан өгөх өөрөөр хэлбэл үйлдвэрийг ажиллуулах хүмүүсийг сургах, үйлдвэрийг угсрах, эхний шатанд ажиллуулахад туслах болно. Хөрөнгө оруулалтын төсөл өргөн цэргий, урт хугацааны хөндлүүлсэн төлбөр, нөхөн төлөлтийн гэрээгээр санхүүжигдэхээр төлсөн хамтын ажиллагаа нь дээр дурдсан салбарын эхлэлтийн ажиллагааны шат, тэрчлэн техник технологийн ашиглалт, бүтээгдэхүүний хяналт, бүрэлдэхүүн хэсгээр хангах хүрээнээс халин, бизнесийн уг хэмжээнээс хол давж бүтээгдэхүүн, үйлчилгээний солилцоог өргөтгөн, янз бүр болгох шатанд хүрнэ. Монголд хөрөнгө оруулалтын санхүүгийн ачаалал нь хөрөнх валютын нөөцийн хязгаарлагдмал хэрэгцээ, урт хугацааны төлбөрөөр хөнгөлөгдөнө.

Ажиллаж байгаа үйлдвэрийг худалдан авахыг хэлдэг лавшруулсан гэрээ буюу гэрээг үйлдвэр нь энэ чиглэлийн хамтын ажиллагааны дэлгэрсэн хэлбэр юм. Түүний бол техникийн бичиг баримт, түүхий эд, ажиллагсдын сургалт, өөрийн үйлдвэрт хэрэглэгдэх тоног төхөөрөмжийн

бүрэлдүүн хэсэг, хагас боловсруулсан бүтээгдэхүүн нийлүүлэх нь олонтаа байдаг. Түншүүд шкал /ханш үнэ төлбөрийн норм/ хөдөлмөрийн болон үйлдвэрлэлийн бусад зардлаа хэмнэн, үйлдвэрлэлийн эмзэг дамжлагыг арилгаж нөөцийг үр ашигтай хэрэглэн ашиг олж болно. Түншүүд үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсгийг солилцож эхлэх, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн технологийг сайжруулах болсон, шинэ машин, тоног төхөөрөмж нэмэх замаар үйлдвэрлэлийн хүчин чадлыг өргөтгөх болсон, эцсийн бүтээгдэхүүний маркетингийн талаар хамтран ажиллах болсон зэрэг улам давшингүй хамтын ажиллагааны үед лавшруулсан гэрээ хийх нь олонтаа байдаг. Үйлдвэрлэлийн шугам бу-юу бүтэн үйлдвэр нийлүүлэхийг оролцуулан лиценз худалдах хэлбэрээр технологи эрчимгүй шилжүүлэх үед хамтын үйлдвэрлэл явуулах нь олонтаа байна.

### 2. 2-р загвар-Маркетингийн хамтын ажиллагааны хэлбэр

Өрнөдийн зах зээл дээр монголын худалдаалах чадвар нь өрнөдийн өрсөлдөгчид төвс ихээхэн доогуур байна. Энэ бол гол нь монголын тал нэлээд амь, хнаар сурч болох талтай маркетингийн ухааны асуудал мөн бөгөөд Монгол, Солонгосын түншүүдийн эдийн засгийн хамтын ажиллагааны нэлээд аятайхан хэлбэрийг олоход тус болж болно. Иймд эдийн засгийн үйл ажиллагаанд үйлчилгээ, чармайлт хэрхэн гаргах, яаж нэр хүндтэй болох мөнхийн маркетингийн ухаан эзэмшихэд Монгол т туслах ажил зохиогууштай байна.

Монголын маркетингийн мэргэжилтнүүдийг Солонгост болох семинар, симпозиум, бага хуралд урьж болно. Мөн Монголоос Солонгосын фирмүүд рүү хүмүүсийг угсруулан явуулж сургаж болно. Энэ нь дээрх байдлыг сайжруулахад тус болно. Монгол ялангуяа Солонгостой үйлдвэрлэлийн хамтын ажиллагаа, хамтын үйлдвэр байгуулах үед Солонгостой байгуулах аж үйлдвэрийн хамтын ажиллагааны гэрээнд хамтын маркетингээр тусгайлан заагт оруулж ч болно. Эдгээр ажиллагаа нь маркетинг, хожмын худалдааны зохих үйлчилгээний хамтын ажиллагааг хангана. Ийм ажиллагаа нь Монголын зах зээлийн талаархи хамтын хүчин чармайлтаар эхлээд Солонгосын маркетингийн зүгширсэн сүлжээг хэрэглэн гуравдах орнуудын зах зээлд хүрч болно. Ийм хамтарсан маркетингийн ажиллагаа нь Монголын экспортыг дэмжиж, түүний маркетингийн зардлыг бууруулж чадна. Энэ нь дэлхийн зах зээлд монголын бүтээгдэхүүнийг гаргах асуудал маркетингийн талаархи хамтын ажиллагаатай ихээхэн уялдана.

Үйлдвэрлэлийг шилжүүлэн авсан монгол түнш нь монголын зах зээл, мөн Солонгосын компани өөрийн сайн зүгширсэн худалдаалах сүлжээ байхгүй зарим зах зээлийг ерөнхийдөө хамарна. Бас янз бүрийн зах зээлийн талбарт хамтын компани байгуулан маркетинг явуулж болно. Эдгээр нь нэлээд нарийн бүх машин, тоног төхөөрөмжтэй уялдсан үйлчилгээ, ашиглалттай ерөнхийдөө холбогдоно.

### 3. 3-р загвар-Худалдааны тусгай хэлбэрийн хамтын ажиллагаа

Солонгосын тал хөнгөн ба өргөн хэрэгцээний зүйлийн үйлдвэрүүдийн үйлдвэрлэлийн технологийг хуримтлуулсан ухаанд хөрөнгө зарахад голлон анхаарч орон нутгийн зах зээлд зориулсан хамтын үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх ёстой. Монголын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгө хөрвөдөг валют биш байгаагаар холбогдсон асуудал, Монголоос мөнгөн хөрөнгө гадагш гаргах бэрхшээлийг үгүйсгэж болохгүй нь зүй ёсны хэрэг. Эдгээр асуудлыг ултай шийдвэрлэх зүй ёсны ухаалаг боломжийг эрэлхийлж болно. Практик ажиллагааны нэг хэлбэр бол монголын талын хүсэлтээр солонгосын түншүүдийн хийж болох янз бүрийн нөхөн төлөх худалдаа юм. Үүнд одоо үйлчилж байгаа худалдааны хэлбэр, эрхийн актууд саад тотгор учруулж болох боловч нөхөн хийх худалдаа нь кинше нь түүхий эдийг судалж, ашиглах чиглэлийн төсөлд нэлээд таарах болно. Энэ талаар солонгос шинэ мөөгийн хангамжийг хүсч байгаа учир туршсан ажиллагаа явуулж болох юм. Монгол гол төлөв түүхий эд, ялангуяа нэвс, зэс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн экспортолж, аж үйлдвэрийн бараа экспортолж байгаа нь бүтцийн хувьд зарим талаар

зохисгүй гэж бодно. Иймд Монгол Солонгост экспортлох чадавхиа нэмэгдүүлж, Солонгос тэдгээр барааг импортлох бэлтгэлээ дээшлүүлдбэл худалдаанд тус болно гэж дүгнэж болно.

#### 4. 4-р загвар-Хөгжлийн хамтын ажиллагааны хэлбэр

Хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаа нь мөн байгалийн нөөцийг ашиглах салбарыг хөгжүүлэхэд голчлон чиглэгдэх ёстой. Бас хөнгөн үйлдвэрийн сектор, үйлчилгээний секторын талаар хамтран ажиллах боломж байна.

Нүүрс, газрын тос, зэс мэтийн байгалийн нөөцийг ашиглах өргөн цар хүрээтэй төслийн зэрэгцээ, аж үйлдвэрийн шинэ салбарын төслийг бодолцох ёстой. Нэлээд үр өгөөжтэй хагас боловсруулсан барааг Солонгос импортлох талын төслийн асуудлыг энэ аж үйлдвэрийн хамтын ажиллагаанд оруулах ёстой гэж бодогдоно.

Зах зээлийн системд шилжиж байгаагийн дагавар үр дүн нь Солонгос, Монгол үйлчилгээний секторт хамтран ажиллах потенциал юм. Гадаадын компаниуд Монголд нэвтэрч байгаагийн улмаас албаны барилга, үзэсгэлэнгийн өрөө, танхим, хувариалзгалын төв барих их шаардлага гарч, цаашдаа барилгын ажил асар их өргөжих болно. Үүний хамт эдийн засгийн тусгай бүс байгуулах нь эгчид буудал, орон сууцны том цогцолбор барихад түлхэц болох далд боломжтой юм. Эдийн засгийн тусгай бүс байгуулах төлөвлөгөө нь эдийн засгийн нээлттэй бодлогын гол гогцоо зүйлийн нэг мөн бөгөөд зардал хэмнэх талтай. Солонгос эдийн засгийн чөлөөт бүсэд экспортын чиглэлийн үйлдвэрийн газрууд байгуулж, өөрсдийн давуу технологиор бараа үйлдвэрлэх, Монголын тиймэрхүү бүтээгдэхүүнтэй жишихэд зардал хэмнэх болно.

Тэр ч байтугай хөнгөн үйлдвэрийн секторт өргөн хэрэгцээний бараа үйлдвэрлэхээр хамтрах нь харилцан ашигтай бөгөөд тиймэрхүү төслийг хэрэгжүүлэхэд алдагдал зайлшгүй бий юм. Тиймэрхүү төслөөр чдээхитэй оролцох нь удаан хугацаанд итгэлцлийг бий болгож чадна. Өргөн хэрэгцээний барааг улам ихэсгэх хүн амын өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээний улмаас Монголын засгийн газар нь энэ секторт хөрөнгө оруулалт, технологи нэвтрүүлэх явдлыг нэмэгдүүлэх болно.

Солонгосын хувьд Монголын байгалийн нөөцийг боловсруулахад тэргүүн зэргийн зорилт тавих болно. Учир нь Солонгос энэ талаар ихээхэн гачигдалтай байгаа бөгөөд удаан хугацааны үндсэн дээр түүхий эдийг тогтвортой хангах нь солонгосын улам өсөн нэмэгдсээр байгаа импортын эх үүсвэрийг олон янзын арга замаар бий болгоход шийдвэрлэх гч холбогдолтой. Иймд байгалийн нөөцийн найдвартай хангамж нь хамгийн шийдвэрлэгч асуудал мөн бөгөөд гадаадаас хангах эх үүсвэрийг олон янзын арга замаар бий болгохыг чармайх ёстой. Монголын хөгжлийн төсөлд оролцох бололцоо нь Солонгосын холбогдох аж үйлдвэрүүдэд итгэл төрүүлэх үндэс болох ёстой. энэ итгэл нь 1990-ээд онд бат бэх байх болно. Хөгжлийн хамтын төсөл бол удаан хугацааны хойшлуулсан төлбөрийн үндсэн дээр /зээлдүүлэгч орны бараа, үйлчилгээг худалдан авах бодолын зээллэгийн журмаар зээл авах ёстой байх/ уг хөгжилд шаардагдах машин, тоног төхөөрөмж, материалаар Солонгос хангах, харин Монгол байгалийн нөөцийг удаан хугацааны турш Солонгост шийлүүлэх зарчмы дээр тулгуурлах ёстой.

#### 5. Дүгнэлт - Солонгос, Монголын хоорондын эдийн засгийн хамтын ажиллагааны хэргийн төлөв

Монголын шинэ байдал, түүний зах зээлийн улмаас Солонгос, Монголын хоорондын эдийн засгийн хамтын ажиллагаа хурдан хөгжихөд саад болох олон хүчин зүйл байсаар байна. Монголын эдийн засгийн дотоод бүтэц нь зах зээлийн чөлөөлөлтийг даган хамгийн өвөрмөцөөр бүрэн өөрчлөгдөж, эдийн засгийн шинэтгэлийн бодлого биелэгдэх ёстой.

Монголд хөрөнгө оруулах, худалдаа хийхэд янз янзын осол байдгийн улмаас солонгосын компаниуд ерөнхийдөө болгоомжилсоор байна. Солонгос, Монголын хууль тогтоомж, худалдааны практикийн ялгаа нь солонгосын компаниудад сэргэмжлүүлэлт болж байна. Монголын

гадаад өр их, гадаад солбилцоо хангалтгүй, зээлийнх нь эргэлт хангалтгүй байгаагийн улмаас ашгаз мөнгөөр гуйвуулахад хүндрэл гарч болно гэж солонгосын компаниуд болгоомжилж байна.

Хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор итгэлцэл, ойлголцлыг төрүүлэхийн тул мэдээллийн үр ашигтай сүлжээ байгуулах, мөн худалдаа, хөрөнгө оруулалтын шийдвэрлэгдээгүй асуудлыг нарийвчлан судлаад учир ухаантайгаар найрсгаар шийдвэрлэх ёстой. Үүний зэрэгцээгээр хоёр орны засгийн газрын хууль тогтоомжийн дэмжлэгтэйгээр санхүү, гадаад арилжаа, хөрөнгө оруулалтын баталгаатай гэрээгээр холбогдсон зарим асуудлаас хоёр орны хэрэгцээнд зохицуулан төлөрийн болзол болон бусад заалтуудыг засварлан сайжруулах хэрэгтэй байна.

Эдийн засаг, улс төрийн харилцаа нь газарзүй, үзэл суртлын ялгааг багасгахад тодорхой хувь нэмэр болно. Солонгос, Монголын хоорондын эдийн засгийн солбилцосны түвшин дээшлэх нь бөмбөрцгийн энэ бүсэд энх тайван, цэцэглэлт тогтоох явдлыг хурдасгах болно. Монгол, Солонгос хоёр эдийн засгийн өргөжин бэхжиж байгаа хамтын ажиллагааныхаа үр шимийг хүртэлсэн чухал түншүүд болох нь дамжиггүй.

Англи хэлнээс орчуулсан Г. СҮХБААТАР  
Ц. БААТАР

Berchtold, Christine: Ableitung von Marketingstrategien aufgrund spezifischer Merkmale von Außenhandelsorganisationen in

Staatshandelsländern gezeigt am Beispiel COMECON, Diss. WU Wien 1982  
Der Fischer Welt Almanach, Zahlen Daten Fakten 1989, 1990 Frankfurt a.M 1989, 1990  
Greer, Thomas V.: Marketing in the Soviet Union, London 1973 Mayer, C.: "Marketing in Eastern European Socialist Countries", in:

University of Michigan Business Review, Jan. 1976, PP 10-18 Meier, Christin:  
Sowjetische Joint Ventures mit westlichen Partnern 1987-1989 Köln 1989

Park, Ki-An: international Marketing (in Korean), Seoul 1989

Park, Ki-An: International Business (in Korean), Seoul 1992

Park, Ki-An (Yu-Pil Wha: Market Entry Strategy of Korean Textile Industry in the Eastern Bloc (in Korean), ITBI, Seoul. 1990

Park, Ki-An: Marketing Strategy in the East-West Trade, The Korean Economic Daily, Seoul 1989 (in Korean)

Shelton, Judy: der Rote Crash, München 1988

Schenk, K.E.: "Perspektiven der industriellen Ost-West Kooperation", in: Wirtschaftsdienst Vol. XII 1975

Steffens, Rolf: D.: Praxis des Osthandels, Hamburg 1973

United Nation: USSR: New Management Mechanism in Foreign Economic Relations, New York 1989

UNCTAD: Ways and Means of Expanding Trade and Economic Relations between Countries having different Economic and Social Systems, Geneva 1984